

Компанийн Засаглалын Хөгжлийн Төв

Утас: 458378 Факс: 458378

Вэбсайт: www.mcqdc.org.mn

(хийгдэж байгаа)

Хаяг: Санхүү Эдийн Засгийн
Дээд Сургууль, В Байр, 403 тоот
Улаанбаатар, Монгол

Холбоо барих хүн: Т. Цэнд-
Аюуш

Гар утас: 99105111

Компанийн Засаглалын Хөгжлийн Төв

Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (КЗХТ) нь байгууллагын болон хувь хүний гишүүнчлэлтэй төрийн бус байгууллага юм. Төв нь Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль (СЭЗДС), Санхүүгийн Зохицуулах Хорооны (СЗХ) санаачлагаар Америкийн Нэгдсэн Улсын Олон Услын Хөгжлийн Агентлагийн Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл Өрсөлдөх Чадвар Төсөл болон Олон Улсын Санхүүгийн Корпорацийн дэмжлэгтэй үүсэн байгуулагдсан.

Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн эрхэм зорилго Монгол Улсад компанийн засаглалыг хөгжүүлэх манлайлагч байгууллага болоход оршдог. Төвийн үйл ажиллагааны зорилтууд:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал, хуулийн зөвлөх, төрийн өмчийн компаниудын менежерүүд, ТУЗ-ын нарийн бичгийн дарга, эрдэмтэд судлаачид болон санхүү/эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлчид болон Монголын бизнесийн удирдагчдад зориулан компанийн засаглалын сургалтуудыг чанартай зохион байгуулж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах
2. Компанийн засаглалын салбар дахь шинжилгээ, судалгааны чадавхийг бэхжүүлэх, бизнесийн байгууллагуудад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх
3. Компанийн засаглалын туршлагыг нэвтрүүлэх, түгээх дэлгэрүүлэх, ойлголт, ач холбогдлыг олон нийтэд сурталчлах

Бүх гишүүдийн анхдугаар хурал болоод удаагүй байна. Уг хурлаар төвийн гишүүд Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон томилон, УЗ-ийн Хороодын бүтцийг тодорхойлсон.

Удирдах Зөвлөлийн гишүүд:

1. Д. Батжаргал – СЭЗДС-ийн захирал бөгөөд КЗХТ-ийн УЗ-ын дарга
2. Д. Дүгэржав- СЗХ-ны гишүүн бөгөөд дэд дарга
3. Ж. Үнэнбат- СЭЗДС-ийн Санхүүгийн Удирдлагын Тэнхимийн эрхлэгч бөгөөд КЗХТ-ийн гүйцэтгэх захирал
4. Э. Оюунбилэг- Хаан Банкны дэд захирал
5. Г. Ганболд- Голомт Банкны үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал
6. Л. Төр-Од – ХасБанк-ны гүйцэтгэх дэд захирал
7. Д. Нармандах- Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны Хөдөлмөрийн зах зээлийн албаны дарга
8. Д. Байлхүү- Төрийн Өмчийн Хорооны зөвлөх

Боломжит УЗ-ийн Хороод:

- Мэргэжлийн Хөгжлийн Хороо
- Гишүүнчлэлийн Хороо
- Компанийн Засаглал, Хөрөнгийн Зах Зээлийн Хороо
- Аудитын Хороо
- Томилгоо, Цалин Хөлсний Хороо

Төвийн гишүүдээс дурьдвал Хаан Банк, Голомт Банк, ХасБанк, Туул Сонгино Усны Нөөц ХК, Баянгол Зочид Буудал ХК, Санхүүгийн Зах Зээлийн Холбоо, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Чоно Корпораци, Мобиком Корпораци, Хөгжил Финанс ББСБ юм. Төв нь одоогийн байдлаар 30 гаруй хувь хүний гишүүнчлэлтэй. 2009 онд бид нийт 36 сургагч багшийг бэлтгэн 15 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлуудад сургалтыг амжилттай зохион байгуулсан. Төвийн санхүүжилт нь сургалтын хөтөлбөрүүдийн орлого, зөвлөх үйлчилгээний орлого, гишүүнчлэлийн татвар, дотоод болон гадаад байгууллагын тэтгэлэг, улсын болон хувийн байгууллагуудын тэтгэлэг юм.

